



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 30 өдөр

Дугаар А/297

Булган сум

Хандив, тусламжийн бараа материалыг татан авахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” тушаалын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч аймгийн хэмжээнд 550.0 гаруй мянган толгой мал хорогдсонтой холбогдуулан Япон Улсын хүмүүнлэгийн тусламж, “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн хандив, Малчдад туслах аянд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн бараа материалыг Улаанбаатар хотоос татахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хандив, тусламжийн бараа материалыг татан авахад шаардагдах 3,375,000 (Гурван сая гурван зуун далан таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Тээвэр хийх иргэнтэй гэрээ байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга, Шуурхай штабын дарга (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 20-ний өдрийн А/297 дугаар  
захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТООС ХАНДИВ ТУСЛАМЖИЙН БАРАА МАТЕРИАЛЫГ  
ТАТАН АВАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д/д	Жолоочийн нэр	Машины марк	Улсын дугаар	Ачааны хэмжээ /тн/	км	Тээврийн зардал
1	2	3	4	5	6	7
1	Б.Эрдэнэбаяр	SCANIA.DC1209	19-69 БУА	25	450	3,375,000
<b>Дүн</b>				<b>25</b>		<b>3,375,000</b>